

### III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

#### АЖЛЫН ДААЛГАВАР

Нэг. Ажлын зорилго

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 17.1.2; 17.1.3-т заасан “хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх малын эм, биобэлдмэлийн болон пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг олон улсын стандартад нийцүүлэн тогтоох” хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэлд ашиглаж буй пестицидийн бүтээгдэхүүн дэх үлдэгдлийн хэмжээ нь олон улсын болон үндэсний стандартад нийцэж байгаа эсэхийг судлах, тодорхойлоход энэхүү зөвлөх үйлчилгээний ажлын зорилго оршино. (36-р тогтоолын холбогдох заалтаас оруулах)

Хоёр. Хамрах хүрээ

Хүнсний зориулалттай импортын болон дотоодод тариалж ургуулж буй үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ дэх пестицид болон натратын үлдэгдлийг тодорхойлох, хүчин төгөлдөр мөрдөж буй олон улсын болон үндэсний холбогдох стандарт, шаардлагуудад нийцэж байгаа эсэх талаар судалгаа хийж, санал дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулна.

**Гурав. Судалгааны үр дүн**

Судалгаа, шинжилгээг олон улсын болон үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөн мөрдөж буй холбогдох **баримт бичиг**, дээж бэлтгэх арга болон шинжилгээний дэвшилтэт арга зүйн дагуу, чанарын шаардлага хангасан цэвэршилт өндөртэй аналитик стандарт бодисоор гүйцэтгэсэн байх ба судалгаагаар Монгол Улсад ашиглахыг зөвшөөрсөн болон бусад олон улсад ашиглаж буй пестицидийн бүтээгдэхүүн дэх үлдэгдлийн хэмжээг тогтоон тодорхойлж, судалгааны үр дүнгээр хийсэн тайлан, судалгаа болон пестицидийн чанар, үлдэгдлийн хүрээнд хүчин төгөлдөр мөрдөж буй стандарт, шаардлагуудын талаар санал дүгнэлт ирүүлнэ.

**Дөрөв. Хугацаа**

Зөвлөх үйлчилгээг 2024 оны 07 сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 30-ны хооронд хийж гүйцэтгэнэ.

**Тав. Судалгааны хүрээнд хийгдэх ажлууд**

5.1 Дотоодод тарьж ургуулсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний хөнөөлт организмтой тэмцэхэд түгээмэл ашиглагдах Хүснэгт.1-т заасан пестицидийн үлдэгдэл болон бусад агуулагдаж болзошгүй пестицид болон нитратын үлдэгдлийг тодорхойлох, хэрэв шинжилгээгээр манай оронд ашиглахыг зөвшөөрсөн пестицидээс өөр төрлийн пестицидийн үлдэгдэл илэрсэн тохиолдолд тэдгээрийн хүлээн зөвшөөгдөх дээд хэмжээ болон аюул учруулах түвшинг тодорхойлох, **эрсдэлийн үнэлгээ өгөх** хүчин төгөлдөр мөрдөгдөж буй олон улсын болон үндэсний холбогдох стандарт, шаардлагуудтай харьцуулах.



5.2 Хүнсний зориулалтаар импортоор орж буй Хүснэгт 3-т заасан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний бүтээгдэхүүнийг пестицид болон нитратын үлдэгдэл илрүүлэх шинжилгээнд хамруулах, пестицидийн үлдэгдэл илэрсэн тохиолдолд нэр төрөл, үйлчлэх бодисыг тодорхойлох, эрсдэлийн үнэлгээ өгөх хүчин төгөлдөр мөрдөгдөж буй олон улсын болон үндэсний холбогдох стандарт, шаардлагатай харьцуулах.

5.3 Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй пестицид, бордооны чанар аюулгүй байдлын болон бүтээгдэхүүн дэх пестицидийн үлдэгдлийн стандартуудыг хянах, бусад олон улсын стандарттай харьцуулах, үндэсний стандартыг хэвээр мөрдөх эсхүл шинэчлэх, олон улсын стандартыг нутагшуулах талаар судалгаа хийж, санал дүгнэлт гаргах.

Хүснэгт 2. Пестицид, нитратын үлдэгдлийн шинжилгээнд хамрагдах дотоодод тарьж ургуулсан бүтээгдэхүүний нэр төрөл, дээжний тоо болон хөрсний шинжилгээ

№	Бүтээгдэхүүний нэр төрөл		Пестицидийн нэр төрөл	Аймаг- сум (дээжний тоо)	Дээжний тоо
1	Үр тариа	1	Глифосат	Сэлэнгэ (25) Төв (20) Дархан-Уул (10) Орхон (5)	60
		2	Метсульфурон метил		
		3	Дикамба хлорсульфурон		
		4	Феноксапроп-П - этил		
		5	2.4 Д бутилын эфир		
		6	Лямбда-цигалотрин,		
		7	Тебуконазол		
		8	Трибенурон метил		
		9	Нитрат		
		10	Бусад		
2	Рапс	1	Клопиралид	Сэлэнгэ (10) Төв (10)	20
		2	Хизалофоп-П-этил		
3	Төмс	1	Флудиоксонил	Сэлэнгэ: Хушаат (10)  Төв: Жаргалант (15) Борнуур (10)	35
		2	Манкоцеб, +металаксил,		
		3	Тирам		
		4	Метрибузин		
		5	Дикват		
		6	Лямбда-цигалотрин		
		7	Имидаклоприд		
		8	Пропамокарб гидрохлорид		
			Римсульфурон		
		9	Нитрат, нитрит		
	Бусад				
4	Лууван	1	Прометрин,	Сэлэнгэ: - Жавхлант (5) - Хушаат (5)	25
		2	Лямбда-цигалотрин		
		3	Имидаклоприд		



		4	Бусад	Төв: - Борнуур (5) - Дархан-Уул(5) - Орхон (5)	
5	Сонгино	1	Пендиметалин	Сэлэнгэ: - Хушаат (10) Төв: - Батсүмбэр (5) - Борнуур (5)	20
		2	Оксифлуорфен		
		3	Лямбда-цигалотрин		
		4	Имидаклоприд		
		5	Нитрат		
		6	Бусад		
6	Өргөст хэмх	1	Манкоцеб, мефеноксам	Улаанбаатарын хүлэмж эрхлэгч томоохон аж ахуйн нэгжүүд (20) Дархан-Уул (10)	30
		2	Лямбда-цигалотрин		
		3	Имидаклоприд		
		4	Нитрат		
			Бусад		
7	Лооль	1	Метрибузин	Улаанбаатар хүлэмж Дэвшил ХХК болон бусад (30) Төв: (10)	40
		2	Лямбда-цигалотрин		
		3	Имидаклоприд		
		4	Бусад		
8	Навчит ногоо	1	Лямбда-цигалотрин	Улаанбаатар (20)	20
		2	Имидаклоприд		
		3	Бусад		
9	Тарвас	1	Лямбда-цигалотрин	Улаанбаатар хотын зах зээл, дэлгүүрүүд. Тарвас тариалдаг бүс нутгуудаас ирсэн дээжинд түүвэрлэн хийнэ.	30
		2	Имидаклоприд		
		3	Нитрат, нитрит		
		4	Бусад		
10	Байцаа	1	Лямбда-цигалотрин	Төв (5) Сэлэнгэ Мандал (10) Дархан-Уул (10) Нийслэл 61-гарам (5)	30
		2	Имидаклоприд		
		3	Нитрат		
		4	Бусад		
11	Чацаргана	1	Лямбда-цигалотрин	Улаанбаатар хотын зах зээл, дэлгүүр	30
		2	Имидаклоприд		
		3	Нитрат		
		4	Бусад		
12	Хөрсөн дэх пестицидийн үлдэгдэл	5	Дээрх бүх пестицидээр	Сэлэнгэ, Төв, Дархан-уул	50
	Нийт дүн				390



Хүснэгт 3. Пестицидийн үлдэгдлийн шинжилгээнд хамрагдах импортын бүтээгдэхүүний нэр төрөл, дээжний тоо

№	Бүтээгдэхүүний нэр төрөл		Пестицидийн нэр төрөл	Дээжний тоо
1	Сонгино	1	Пендиметалин	20
		2	Оксифлуорфен	
		3	Лямбда-цигалотрин	
		4	Имидаклоприд	
		5	Бусад пестицид илрүүлэх	
2	Өргөст хэмх	1	Манкоцеб, мефеноксам	20
		2	Лямбда-цигалотрин	
		3	Имидаклоприд	
		4	Бусад пестицид илрүүлэх	
3	Лооль	1	Метрибузин	20
		2	Лямбда-цигалотрин	
		3	Имидаклоприд	
		4	Бусад пестицид илрүүлэх	
4	Навчит ногоо	1	Лямбда-цигалотрин	20
		2	Бусад пестицид илрүүлэх	
5	Байцаа	1	Пестицид илрүүлэх	20
6	Алим	2	Пестицид илрүүлэх	20
7	Усан үзэм	3	Пестицид илрүүлэх	20
8	Банан	4	Пестицид илрүүлэх	20
9	Жүрж	5	Пестицид илрүүлэх	10
10	Тарвас	6	Пестицид илрүүлэх	10
	<b>Нийт</b>			<b>180</b>

5.5 Дотоодод тарьж ургуулсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ дэх түгээмэл ашиглагддаг пестицидийн үлдэгдлийг тодорхойлох шинжилгээний үр дүнгийн бодит үнэн байдлыг баталгаажуулах зорилгоор энэхүү ажлын даалгаврын Хүснэгт.2 -т тусгасан дээжний тооноос түүвэрлэн 5-аас доошгүй дээжийг энэхүү хүрээнд олон улсад итгэмжлэгдсэн үндэсний болон бусад орны лабораторид шинжлүүлж, харьцуулсан дүнг ирүүлэх.

5.7 Хүнсний зориулалтаар импортоор орж буй үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний бүтээгдэхүүн дэх пестицидийн үлдэгдлийг илрүүлэх, доторхойлох шинжилгээний үр дүнгийн бодит үнэн байдлыг баталгаажуулах зорилгоор энэхүү ажлын даалгаврын Хүснэгт.3 -т тусгасан дээжний тооноос түүвэрлэн 5-аас доошгүй дээжийг энэхүү хүрээнд олон улсад итгэмжлэгдсэн үндэсний болон орны лабораторид шинжлүүлж, харьцуулсан дүнг ирүүлэх.

Зургаа.Тайлангийн иж бүрдэл

1. Энэхүү ажлын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг тендерийн баримт бичигт заасан хугацаанд ирүүлэх ба ажлын даалгаварт заасан бүх ажлыг гүйцэтгэсэн тухай нэгдсэн тайланг ирүүлнэ.
2. Пестицид, нитратын үлдэгдлийн шинжилгээний аргын баталгаажуулалтын тайланг ирүүлэх ба үүнд дараах зүйлүүдийг багтаасан байна. Үүнд:
  - a. Гүйцэтгэлийн үзүүлэлт
  - b. Илрүүлэх болон тодорхойлох хязгаар (LOD/LOQ)



- c. Шугаман чанар болон ажлын муж (Linear and Working range)
- d. Үнэн зөв байдал (Trueness): Хэвийх утга(Bias), Сэргээгдэх чадвар (Recovery)
- e. Давтац (Precision): Тохирц (Repeatability, Завсар дундын тохирц (Intermediate repeatability), Таарц (Reproducibility)
- f. Хэмжлийн эргэлзээ (Measurement Uncertainty)

3. Тайланд зөвлөх үйлчилгээний ажлын тайлангийн салшгүй хэсэг болох зөвлөхийн лабораторийн шинжилгээний болон харьцуулсан лабораторийн шинжилгээний дүнгүүд, шинжилгээний үр дүнгээр хийсэн судалгаа, үндэсний болон олон улсын холбогдох стандартын талаарх судалгаа дүгнэлт, санал зэргийг багтаасан байна.

Зөвлөх үйлчилгээний ажлын тайланг 3 хувь хэвлэмэл, 1 хувь электрон файл хэлбэрээр үйлдэж Захиалагч тал болох ХХААХҮЯ-наас томилсон ажлын хэсгээр хэлэлцүүлэн хүлээлгэж өгнө.

